



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 86

Онхи

Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох  
тэргүүлэх чиглэлийг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2.10 дахь хэсэг, 3.3.1, 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООЖ НЬ:

- Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгох тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.
- Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Цогхийморь)-д үүрэг болгосугай.





Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар  
Хуралдааны 86 дугаар тогтоолын хавсралт

Хоршоог хөгжүүлэх сангаас зээл олгоход  
баримтлах чиглэл

№	Эдийн засгийн салбар	Чиглэл
1	Хүнсний үйлдвэр	<ul style="list-style-type: none"> <li>Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li> <li>Талх, нарийн боов гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li> <li>Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах, худалдаалах</li> <li>Хоол үйлдвэрлэл</li> </ul>
2	Хөнгөн үйлдвэр	<ul style="list-style-type: none"> <li>Төмөр эдлэл үйлдвэрлэл</li> <li>Оёдол эсгүүр үйлдвэрлэл</li> <li>Гутал үйлдвэрлэл</li> <li>Модон эдлэл /мужаан, гэрийн тавилга/</li> <li>Сүлжмэл, нэхмэл, ноос, ноосон бүтээгдэхүүн, ноолууран эдлэл</li> <li>Хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулах</li> </ul>
3	Газар тариалан	<ul style="list-style-type: none"> <li>Төмс, хүнсний ногоо</li> <li>Мод, жимс жимсгэнэ тариалах</li> <li>Хүлэмжийн аж ахуй</li> <li>Тэжээлийн ургамал тариалалт</li> </ul>
4	Мал аж ахуй	<ul style="list-style-type: none"> <li>Арьс, шир боловсруулах</li> <li>Эсгий эдлэл</li> <li>Мал үржлийн ажил үйлчилгээ</li> <li>Мал эмнэлгийн ажил үйлчилгээ</li> <li>Гахай, шувууны туслах аж ахуй</li> <li>Эрчимжсэн мал аж ахуй</li> </ul>
5	Барилга	<ul style="list-style-type: none"> <li>Блок, тоосго, замын өнгөт хавтан үйлдвэрлэл</li> <li>Зөөврийн сууц, төмөр хашаа, хийц</li> </ul>
6	Үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>Үсчин, гоо сайхан маникюр</li> <li>Авто засвар, дугуй засвар</li> <li>Гагнуур</li> <li>Гутал засварын үйлчилгээ</li> <li>Зочид буудлын үйлчилгээ</li> <li>Аялал жуулчлал</li> <li>Алт мөнгөний дархан</li> </ul>